

БНСУ-ын Цаг уурын байгууллагаас зохион байгуулсан “Цаг уурын үйлчилгээний холбоо мэдээллийн технологи” сэдэвт олон улсын сургалтанд хамрагдсан тайлан

2017 оны 09–р сарын 03-наас 23-ны хооронд БНСУ-ын Цаг уурын байгууллагаас зохион байгуулсан “Цаг уурын үйлчилгээний холбоо мэдээллийн технологи” сэдэвт олон улсын сургалтанд хамрагдсан. Сургалт нь нийт 21 өдрийн турш батлагдсан хөтөлбөрийн дагуу явагдсан бөгөөд мэдээллийн технологийг цаг уурын үйлчилгээний ажилд ашиглаж буй байдал, Супер компьютерийн төв, Хиймэл дагуулын төв болон Үндэсний мэдээллийн сангийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай тус тус танилцсан.

Сургалт, семинарын хичээлийн сэдэв: БНСУ-ын цаг уурын байгууллагын үйл ажиллагаа, түүнийг дотоод үндсэн ажилчид болон бусад хэрэглэгчдэд мэдээллийн технологийн дэвшилтэт арга технологиор хэрхэн хүргэж буй байдал, мэдээллийн санг хэрхэн оновчтой зөв зохион байгуулах арга туршлага, цаг уурын мэдээллийн сүлжээний бүтэц зохион байгуулалт болон түүнийг ашиглан радар, хиймэл дагуул, автомат станц, тоон прогнозын загварын үр дүн болон бусад мэдээ, мэдээллийг хэрхэн цаг алдалгүй, найдвартай хүлээн авч, түгээх, зэрэг сэдвээр БНСУ-ын цаг уурын байгууллагын мэргэжилтнүүд хичээл зааж, өөрсдийн арга туршлагаас хуваалцсан бөгөөд ДЦУБ-аас мэдээлэл технологийн чиглэлээр баримталж буй бодлого, цаашдын чиг хандлагын талаар буюу WIS (WMO Information System)–ийн бүтэц зохион байгуулалт, түүний үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчимын талаар ямар ямар шинэ өөрчлөлт, боломж гарсан тухай танилцуулсан болно.

Энэхүү сургалтанд хамрагдснаар цаг уурын мэдээллийн сүлжээ болон мэдээллийн санг хэрхэн оновчтой, зөв зохион байгуулах, ингэснээр мэдээллийг цаг алдалгүй найдвартай хүлээн авч, цааш нь хэрэглэгчдэд түгээх ажиллагааг хялбар болгож автоматжуулах нөхцөл боломжийн талаар туршлага судалсан.

Тус төвийн хувьд мэдээллийн технологийг ашиглан хэрэглэгч байгууллагуудад мэдээллийг түргэн туурхай, найдвартай хүргэх асуудал ч мөн хурцаар тавигдаж байна. Үүний тулд боловсон хүчинг сайтар бэлтгэх, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх мөн нөгөөтэйгүүр мэдээллийн санг шинэчлэн зохион байгуулж, хэрэглэгчдэд хүргэж буй мэдээллийн хүртээмж, ойлгомжтой байдал зэргийг сайжруулах шаардлагатай гэж бодож байна.

